

ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 18

№26/02

Дархан-Уул аймаг

**“Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

“Дархан зочид буудал” ХК-ийн 2026 оны 03 сарын 20-ны төлөөлөн удирдан зөвлөлийн гишүүдээс санал авсан хуудасны дүн, Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэх заалт, Санхүүгийн хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Дархан зочид буудал” ХК-ийн 2026 оны ээлжит хурал 2026 оны 04 сарын 30-ны өдөр 14:00 цагт Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центропонт төв “Бурхан халдун групп”-ын байранд хуралдуулсугай.
2. “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 - Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 - Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-н гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах.
 - 2026 оны төлөвлөгөөг хэлэлцэж баглах.
 - ТУЗ-н нарийн бичгийн даргыг томилох тухай.
3. “Дархан зочид буудал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг **Хавсралт 1**, хурлын зарыг **Хавсралт 2** хурлын дэгийг **Хавсралт 3** хуралтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт 4**, хуралд санал авах саналын хуудасны загварыг **Хавсралт 5**-д тус тус баталсугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2026 оны 03 сарын 20-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлж, олон нийтэд 3 дугаар сарын 23-нд заралсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
6. Компанийн ээлжит хурал удирдах даргаар П.Чимгээг, Тооллогын комиссын даргаар Ю.Түвшинтөгс, гишүүнээр Т.Оюунцэнэг нарыг тус тус томилсугай.
7. Тус тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг бэлэн болгож 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

27-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

8. Компанийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гарсангай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх давтан зарыг одөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2026 оны 04 сарын 08-ний одөр дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга П.Чимгээл даалгасугай.
9. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг ТУЗ-н нарийн бичиг П.Чимгээ-д гаргаж өгөхийг Гүйцэтгэх захирал Э.Алтанзулд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗОВЛОЛИЙН ДАРГА



П. АЛИМАА